



Худалдан авах ажиллагааны цахим системийн төлөвлөлтийн модулийн шинэчлэлийн заавар

Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаартай тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд шинэчлэл хийсэн бөгөөд дараах зааврын дагуу төлөвлөгөө боловсруулна.


- ❖ Захиалагчийн админ эрхээр нэвтрэн орж “Төлөвлөгөө боловсруулах” цэсийн Төсөл арга хэмжээ хэсэгт дарна. Үүний дараа “Нэмэх” товч дээр дарж дараах зургийн дагуу мэдээллийг оруулаад “Хадгалах товч” дарна.




- ❖ Тухайн онд хэдэн төсөл арга хэмжээ батлагдсан тоогоор мөр үүссэн байна. Мөн өгсөн загварын дагуу төсөл арга хэмжээг импортлож оруулах боломжтой.



- ❖ Ерөнхий төлөвлөгөө цэсийн “Жагсаалт” хэсэгт тухайн оны Ерөнхий төлөвлөгөөний хавтсыг үүсгэнэ.




- ❖ Үүний дараа тус хавтас руу дарж ороод “Нэмэх” товч дарж төсөл арга хэмжээнээсээ сонгож Ерөнхий төлөвлөгөөг нэг нэгээр нь үүсгэнэ.





- ❖ Бүх төлөвлөгөөг үүсгэсний дараа “Илгээх” товч дарж **БАТАЛГААЖУУЛАГЧ** руу илгээнэ.

❖ **Баталгаажуулагч** гэдэг нь Захиалагч админ эрхээс ирсэн Ерөнхий төлөвлөгөөг баталж Төсвийн ерөнхийлөн захирагч /ТЭЗ/-д илгээдэг захиалагч байгууллын төлөөлөл эрх бүхий этгээд буюу удирдлага байна.


- ❖ Тус хэрэглэгчийн эрхийг Захиалагчийн админ эрхээр дэлгэцийн баруун дээд талын “Тохиргоо” цэсийг сонгож “Хэрэглэгчийн мэдээлэл” хэсэгт “Нэмэх” товч дарж хэрэглэгчийг нэмнэ.



- Хэрэглэгчийг үүсгэсний дараа  тэмдэгт дээр дарж тус Баталгаажуулагч эрхийг сонгож хадгалан хэрэглэгчийн эрхийг тохируулна.



- Үүний дараа тус Баталгаажуулагч эрхээрээ нэвтэрч өөрийн байгууллагын Ерөнхий төлөвлөгөөг хянан, баталгаажуулснаар “Захиалагч баталсан” төлөвт шилжинэ.



- Баталгаажуулсан төлөвлөгөө тухайн байгууллагын ТЭЗ-д шууд харагдах бөгөөд ТЭЗ эрхээрээ баталгаажуулснаар “ТЭЗ баталсан” төлөвт шилжинэ. ТЭЗ баталсны дараа тус төлөвлөгөөг Сангийн яаманд шууд харагдах бөгөөд Сангийн яам баталснаар “Сангийн яам баталсан” төлөвт шилжинэ.
- Ингэснээр Захиалагч админ эрхээрээ Ерөнхий төлөвлөгөөгөө нийтлэх боломжтой болно.